

Ким Жон Уны (Ким Жон Ын) эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ ба Си Зиньпингийн нарны илч бодлого^{1*}

Пак Жун Чол (Кёнсан Үндэсний Их Сургуулийн профессор)*
Жон Ын И (Кёнсан Үндэсний Их Сургуулийн судлаач профессор)**

Товч агуулга: Ким Жон Ун засгийн эрхийг барьсан энэ гурван жилийн (2012-2014 он) хугацаанд Умард Солонгос нь цөмийн зэвсгийн хөгжил болон эдийн засгийн хөгжлийг хамтад нь зэрэгцүүлэн хөгжүүлэх “эдийн засаг-батлан хамгаалахын чиг шугам”-ыг батласан. Хятад, Умард Солонгосын харилцаа нь цэргийн талаасаа түгшүүртэй харилцаатай байгаа бөгөөд улс төрийн талаасаа хүйтэн хөндий байдал нь хэвээр байна. Гэвч Хятад, Умард Солонгосын харилцаа нь эдийн засгийн талаасаа нэлээд халуун дулаан харилцаатай ба Умард Солонгосын эдийн засаг нь Хятадаас ихээхэн хамаарч байна.

Си Зиньпингийн удирдлага доорх Хятад улс нь Хятад-Америкийн өрсөлдөөнөөс болоод Умард Солонгосын улс төр, цэргийн ач холбогдолыг орхигдуулж болохгүй юм. Си Зиньпинг нь цэргийн талаасаа Умард Солонгосын цөмийн асуудалд анхааруулга өгөхийн зэрэгцээ эдийн засгийн талаасаа Умард Солонгосын талаарх нарны илч бодлогыг чухалчилж байна. Энэхүү Си Зиньпингийн нарны илч бодлого нь Ким Жон Уны тогтолцооны бэхжилтийн тулгуур болж байна.

1. Зохиогчид нь өнгөрсөн 10 орчин жилийн хугацаанд Хятадын Бээжин, Хятад, Умард Солонгосын хилийн бүсийг гол цөмөө болгон судалгаа хийж ирсэн бөгөөд энэхүү судалгаагаар дамжуулан Умард Солонгос, Хятадын өөрчлөлт шинэчлэлийг судалж байна. Зохиогч нь Умард Солонгосын дүрвэгсэд, Хятад, Умард Солонгосын бизнесмен, эрдэмтэд, Ким Ил Соны Их Сургуулийн профессор зэрэг хүмүүстэй ярилцага, уулзалтыг хийсэн. Мөн Хятадын Гадаад Хэргийн Яам зэрэг улс тус бүрийн хүйтэн дайны үеийн нууцаас ил болсон баримт бичгүүдийг судласан болно. Энэхүү өгүүлэл нь зохиогчдын тавьсан илтгэл дээр суурилан засварлан бичигдсэн болно.

Монгол Улс нь ЗХА-ийн улс төрийн түгшмэл байдал болон эдийн засгийн хамтын ажиллагааг хамтад хэрэгжүүлж байгаа нөхцөл байдлыг сайтар бодох хэрэгтэй. Монгол Улс нь Умард Солонгосын хилийн бүсийн эдийн засгийн нээлттэй бүсэд гарснаар эдийн засгийн ашиг сонирхолоо өргөжүүлэх болон Солонгосын хойг дахь нөлөөгөө нэмэгдүүлэх хэрэгтэй. Жишээ нь Ким Жон Ун засаг захиргаанаас хилийн чанад руу ажиллах хүч ихээхэн илгээж байгаа тул Монголын байгаль болон дэд бүтцийн хөгжилд Умард Солонгосын ажиллах хүчийг ашиглан Монгол, Солонгосын хойгийн хооронд ашиг хамгийн их байх санал төлөвлөгөөг олох хэрэгтэй.

Түлхүүр үгнүүд: Ким Жон Ун, Си Зиньпин, Хятад, Умард Солонгосын харилцаа, нарны илч бодлого, эдийн засгийн шинэчлэл, Умард Солонгосын эдийн засаг-батлан хамгаалахын параллел бодлого

Abstract: During the three years of Kim Jong Un's regime (2012-2014), North Korea adopted a "Economy-Defense Parallel Policy" targeting for a simultaneous development in both nuclear weapon and economy.

The Sino-North Korean relations, from military perspective, encounter with tension provoked by nuclear issue of North Korea while from political view, they are still in cold state. However, Sino-North Korean relations represent a strong economical link and North Korean economy is inevitably being subordinated to China.

According to China-American competition structure under the regime of Xi Jinping, the political and military importance of North Korea can never be disregarded. Even though Xi Jinping, from military policy, warns against North Korean nuclear issues but from economic policy, he adopts the Sunshine Policy with North Korea at the same time. This Sunshine Policy of Xi Jinping serves as a forming basis of maintenance of system of Kim Jong Un's regime.

Mongolia should understand this contradictory situation well in which political tension and economic cooperation in Northeastern Asia proceed at the same time. Mongolia should play a leading role in advancing to the opening region of border area of North Korea. This way, Mongolia will be able to achieve the increase of economic advantage and exercise its influence leverage to North-South of Korean Peninsula. For example, currently, Kim Jong Un's regime launches laborer to foreign countries in great quantity. Considering this fact, Mongolia can take advantage of North Korean workforce in terms of resources and infrastructure development. Based on this, Mongolia should seek for solution to maximize the profits between Mongolia and Korean Peninsula.

Key words: Kim Jong-Un, Xi Jinping, Sino-North Korea Relations, Sunshine Policy, Economic Reform, North Korea's 'Economy-Defense Parallel Policy'

* * *

**Зах зээл ба эдийн засгийн тусгай бүсээр дамжуулан эдийн засгийг
сэргээх**

2011 онд Ким Жон Ил (Ким Чен Ир)- ийг нас барсаны дараа Ким Жон Ун нь харьцангуй амжилттайгаар засгийн эрхийг гартаа авч өөрчлөн зохион байгуулалтыг хийж байна. Ким Жон Ун засгийн эрхийг авсан энэ 3 жилийн хугацаанд эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээний талаар удаа дараагийн мэдэгдлүүдийг хийсэн. Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ гэдэг нэр томъёо нь Монголын эдийн засгийн нээлттэй шинэчлэл хэмээх нэр томъёотой адилхан утгатай юм. Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ гэдэг нь өөрөөр хэлбэл эдийн засгийн тусгай бүсээр дамжуулан нээлттэй байдал болон зах зээлчлэлээр шинэчлэлийг хоёр байдлаар байгуулах явдал юм.

Ким Чен Ир-ийн үед 2002 оны 7 сарын 1-ний эдийн засгийн шинэчлэлээр үнэ өртөг, цалин хөлсийг нэмэх, хуваарилалтын системийг шинэчлэх, үйлдвэр, аж ахуйн нэгжийн бие даах чадварыг нэмэгдүүлэх зэргийг хийсэн бөгөөд үүний дараагаар огцом хийсэн энэхүү зах зээлийн өөрчлөлтөөс болж сөрөг нөлөө бий болсон тул эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээг дахин буцаах зэрэг бэрхшээлийг амссан. Ким Жон Ун засгийн эрхийг барьж байгаа энэ 3 жилийн хугацаанд нийслэл Пёньян болон Нажин, Сонбуны бүс нутгийн нээлттэй шинэчлэлийн үр дүн товойн гарч ирж байна. Умард Солонгосын зах зээлийн эдийн засагчлал нь ард түмний дарамт шахалтаар Умард Солонгосын засаг захиргаанаас үг дуугүйгээр хүлээн авч байгаа арга барилаар хөгжиж байна.

Ким Жон Уны үеийн эдийн засгийн тусгай бүс нь 1980 оны эхэн үеийн Хятадын эдийн засгийн тусгай бүстэй адилхан байгаа бөгөөд Умард Солонгос нь нээлт хийх талаас нь харвал дэлбэрэх бодисын үүргийг гүйцэтгэж байна. Эдийн засгийн тусгай бүсдээ гадаадын аж ахуйн нэгжийн дан ганц хөрөнгө оруулалтын хэлбэрийг татаж

байгаа бөгөөд цаашид Өмнөд Солонгос, Хятад, Орос, Япон зэрэг бүс нутгийн орнуудын аж ахуйн нэгжээр тэлэх төлөвтэй байна. Умард Солонгос нь 1991 онд хамгийн анх Нажин-Сонбуны бүс нутгийг эдийн засгийн тусгай бүс болгосон. Энэ нь Пёнъянаас алс хол оршдог бүс нутагт “шумуулны тор шиг нээлт”-ийг сонгосон явдал болсон юм. Ким Чен Ир-ийн үед “Сонгүний улс төр”-ийг цөмөө болгосон эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ болон эдийн засгийн тусгай бүс нь амжилтгүй болсон. Гэвч Ким Жон Уны үеийн Пёнъян болон хилийн бүс нутгийг нээлттэй болгох явдал нь Ким Чен Ир-ийн үеийнхээс өөр хэлбэрээр явагдаж байна. Иймэрхүү зах зээлчлэх үйл явц болон эдийн засгийн тусгай бүс нь Умард Солонгосын эдийн засгийн нээлттэй шинэчлэлийн хөдөлгөгч хүч нь болж байна. Өмнөд Солонгосын зарим судлаачид Ким Жон Уны үеийн “улс төрийн удаан шинэчлэлт ба эдийн засгийн бүх талын шинэчлэл”-ийн талаар үл илгэсэн байдлаар харж байгаагаа илрэхийлэхийн зэрэгцээ мөн эдийн засгийн сэргэлтийн ашиг хонжоог Пёнъян болон зарим хилийн бүс нутгаас л авч байна хэмээн шүүмжилж байна.

Өлсгөлөнгөөс хойш Умард Солонгосын эдийн засаг нь Хятадын нээлттэй шинэчлэлийн эхлэлийг санагдуулам байна. Сүүлийн үед Пёнъяны тусгай хот, Расоны тусгай хот, Кесоны тусгай бүс нутаг зэрэг төрөл бүрийн тусгай бүс болон хилийн бүс рүү чиглэсэн эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээг нэлээд гүнзгий авч байна. Нээлттэй шинэчлэлийн далайц нь бүх талыг хамрахын зэрэгцээ хурд нь бага багаар нэмэгдэж байна. Өнгөрсөн 10 орчим жилийн хугацаанд Умард Солонгосын эдийн засаг аажимаар сэргэж байгаа нь ажиглагддаг. 2014 оны урьдчилсан тооцоогоор Умард Солонгосын нэг хүн амд ноогдох орлого Өмнөд Солонгосын нэг хүн амд ноогдох орлогын 1/20-ээс доогуур, нийт жингээр нь авч үзвэл Умард Солонгосын эдийн засгийн хэмжээ нь Өмнөд Солонгосын эдийн засгийн 1/25 -1/40-өөс хэтрэхгүй байгаа бөгөөд Умард Солонгосын эдийн засгийн өсөлтийн ололт амжилтыг статистикийн үүднээс судлах нь амаргүй байдаг. Гэвч Ким Жон Уны үед нийгэм соёлын өөрчлөлт эрч хүчтэй бий болж байгаа талаас нь харвал Умард Солонгосын нээлттэй шинэчлэл нь гүнзгийрч байгаа гэсэн анализ хийж болох юм.

Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ

Ким Жон Ун нь 2012 оны 4 дүгээр сарын 15-ны Нарны Өдрийн илтгэлдээ “ард иргэдийнхээ бүсийг чангалахгүй байна” хэмээн мэдэгдсэн. Үүний тулд тусгай үйл ажиллагааны хөтөлбөрөөр 2014 оны 4 сард Ардын Дээд Хурлын Байнгын хорооны тогтоолоор худалдааны хууль, гаалийн хууль, цагаачлалын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан². Түүнчлэн Умард Солонгосын засаг захиргаа нь 2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “өөрсдийн арга хэлбэртэй шинэ эдийн засгийн тогтолцоог байгуулах тухай” гэсэн эдийн засгийн шинэчлэлийн шинэ арга хэмжээг зарласан. Үүнийг 6.28-ны арга хэмжээ гэх болсон³. Энэ арга хэмжээ нь дотооддоо газар тариалан, бизнесийн хувьд өргөжилтийг авчирч байгаа бөгөөд гадаад талаасаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах байдлаар эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийг урагшлуулж байна. Хоршоололын фермүүдын бүтцийн хэмжээ нь 10-25 хүнтэй байсаныг 4-6 хүн болгон бууруулах, зорилтот үйлдвэрлэлийн хэмжээ хэтэрсэн бүтээгдэхүүний нийт хэмжээг ферм эрхлэгч нь өмч, үйлчилгээ, худалдааны салбар дахь улсын байгууллага болон түнш байгууллагын нэрээр хувийн хөрөнгө оруулах явдлыг хуульчилсан арга хэмжээ зэргийг багтааж өгсөн. Үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн заримд нь үйлдвэрлэл явуулах анхны зардлыг улсаас хөрөнгө оруулах ба аж ахуйн нэгжүүд нь түүхий эдээ чөлөөтэй худалдан авч бүтээгдэхүүнээ арилжаалах бөгөөд борлуулалтын орлогыг улс болон холбогдох аж ахуйн нэгжид тодорхой тогтсон харьцаагаар хуваарилна. 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдөр аж ахуйн нэгжийн талаарх “Менежерийн хариуцлагын удирдлагын тогтолцоо”-г бүх талаас нь хэрэгжүүлэхээ мэдэгдсэн. 12.1-ний арга хэмжээ нь аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн төлөвлөлт, худалдан авалт, бараа бүтээгдэхүүний борлуулалт болон хуваарилалтыг аж ахуйн нэгжийн хариуцлага дор хэрэгжүүлэхээр болсон юм. Энэ арга хэмжээ нь одоо байгаа

2. 연합뉴스 2013.3.18

3. Умард Солонгосын эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээний талаар Умард Солонгосын дотоод болон гадаад талаас харвал өөдрөг ч тал, гутиранги ч тал байна. Умард Солонгосын эрх баригчдын эдийн засгийн албан ёсны бодлого нь үндсэн давхаргын эдийн засгийн ашигт чиглэсэн бөгөөд хувийн хэсгийг бууруулах зорилго хамрагдаж байгаа учир юм. 2002 оны 7.1-ний эдийн засгийн хөгжлийн арга хэмжээний сөрөг тал дараах байдалтай байна. Умард Солонгост зах зээл бэхжиж байгаа ч гэсэн Умард Солонгосын эрх баригчид ашгийг Умард Солонгосын үндсэн давхаргынханаар дэмжүүлэхээр хичээж байна. Эдийн засгийн өсөлтийн дагуу ашгийг Сонгуны эдийн засгийн хэсэг эзлэж байна.

төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн зарчмын дагуу үйлдвэрлэлийн зорилтот хэмжээг тушаалаар дамжуулан хийдэг байсан хэлбэрээс нь ангижруулсан. Үүнээс гадна, орлогоосоо газар, тоног төхөөрөмж ашиглалтын хөлс, цахилгааны төлбөр зэргийг улсад тушааж үлдсэн орлогоо үр бүтээлээсээ хамааран хуваарилдаг цалингийн ялгавартай тогтолцоог оруулж ирсэн.

2002 оны 7.1-ний арга хэмжээтэй харьцуулбал 2012 оны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ нь дараах онцлого шинжүүдтэй байна. Түүхий эд, үйлдвэрлэлийн материалын зах зээлд захын худалдааг хүлээн зөвшөөрсөн. Бүтээгдэхүүний үнийг тогтоохдоо зах зээлээс бий болсон үнээр тогтоохыг хүлээн зөвшөөрсөн. Мөн хөдөлмөрийн хүч, цалин хөлсийг бие даан шийдэх эрхийн талаас нь хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг баталгаажуулан ур чадвараасаа хамааран цалин хөлсийг ялгаатай байх талыг нь баталгаажуулж өгсөн. Түүнчлэн 6.28 болон 12.1 арга хэмжээгээр дамжуулан гадаад валютын арилжааны дансыг хүлээн зөвшөөрсөн.

2013 оны 3 дугаар сарын 31-нд Хөдөлмөрийн намын төв хорооны бага хурал дээр Ким Жон Ун нь “эдийн засгийн хөгжил, цөмийн зэвсгийн хөгжлийг хамтад нь зэрэгцүүлэн хэрэгжүүлэх чиг шугам”-ыг баталсан. Энэ талаар Өмнөд Солонгосын засгийн газар нь Ким Жон Уны засаг захиргаа үүндээ үнэнч байж, үүнийгээ биелүүлнэ гэдэгт эргэлзэж байгаа. Гэвч Си Зиньпин нь Ким Жон Уны засаг захиргааны талаар бодлого явуулахдаа аюулгүй байдал, эдийн засгийг тус тусад салгасан улс төр, эдийн засгийг заагласан бодлогоор өөрөөр хэлбэл Хятад маягийн нарны илч бодлогоор ойртож байна.

2013 оноос эхлэн Хөдөлмөрийн Намын Төв Хороон нь аймаг бүрт эдийн засгийн хөгжлийн бүсийг байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дараагаар дунджаар хоёр сар тутамд нэг газрыг эдийн засгийн тусгай бүс болгон шийдвэрлэсэн. Умард Солонгосын эдийн засгийн тусгай бүс нь төвийн болон хөдөө орон нутгийн түвшиний тусгай бүс гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжлийн бүс нь хөдөө орон нутгийн онцлогт тохирсон эдийн засгийн тусгай бүс юм.

2013 оны 5 дугаар сарын 29-нд Ардын Дээд Хурлаас эдийн засгийн хөгжлийн бүсийн тухай хуулийг багалсан. Эдийн засгийн хөгжлийн бүсийн тухай хуулийн гол цөм нь эд хөрөнгө, орлого, оюуны өмчийн эрх зэрэг хөрөнгө оруулагчийг хамгаалах, Умард Солонгосын өнөөгийн хуулиар газар түрээслэх хамгийн дээд талын хугацаа нь 50 жил байхаар тогтоосон тал юм. Хөрөнгө оруулагчид бизнесээ явуулахад шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг импортлоход татвараас чөлөөлөх, гадаад валют, ашиг орлого, хөрөнгөө гадаад руу чөлөөтэй шилжүүлэх боломжийг олгосон. Умард Солонгосын дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулсан компаний хувьд газрын сонголтод давуу эрх өгч ашиглалтын төлбөрөөс нь чөлөөлөх тусгай нөхцөлийг олгосон. Эдийн засгийн хөгжлийн бүс бүрт бүсийн аялал жуучлалын нөөцийг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийн бүс дэх компаниуд нь аялал жуучлал, зочид буудлын бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийг олж авахад тэргүүлэх эрхийг олгох тал дээр анхаарлаа хандуулсан. Расоны эдийн засаг, худалдааны бүсийн тухай хуультай харьцуулбал хувийн аюулгүй байдлын тухай заалтыг сайжруулсан бөгөөд хөгжлийн төлөөх холбогдох этгээдээр Умард Солонгосын аж ахуйн нэгж, байгууллагыг нэмж өгсөн явдал нь онцлог юм. Эдийн засгийн хөгжлийн бүсийн дотор газар, барилга байгууламжийг дахин түрээслэх явдлыг зөвшөөрсөн зүйл нь Расоны эдийн засаг, худалдааны бүсийн тухай хуулинд байхгүй. Эдийн засгийн хөгжлийн бүсийн тухай хууль нь Расоны эдийн засаг, худалдааны бүс болон Хванкымпён, Вихва арлын эдийн засгийн бүс, Кесоны аж үйлдвэрийн бүс, Кымган уулын олон улсын аялал жуучлалын тусгай бүсэд үйлчлэхгүй.

2013 оны 10 дугаар сарын 16-17-ны өдөр Пёньян дахь Янгагду зочид буудалд “эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн талаарх олон улсын симпозиум”-ыг зохион байгуулсан. Мөн Солонгосын хөдөлмөрийн намын төв хорооны бага хурлаар гадаад худалдааны олон тулгуур, төрлийн биелэлт, аялал жуулчлалыг эрчимжүүлэхийн тулд аялал жуулчлалын бүсийг байгуулан аймаг бүрийн нөхцөл байдалд тохирсон эдийн засгийн хөгжлийн бүсийг байгуулах талаар шийдвэрлэсэн. 2013 оны 11 дугаар сард эдийн засгийн тусгай бүс нь Шиньжү хотоос эхлэлтэй бөгөөд эдийн засгийн хөгжлийн 13 бүсийг зарласан.

2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Ким Жон Ун нь нам, улс, цэргийн удирдлагуудад “хөгжлийн бодит шаардлагад нийцсэн бидэнд тохирсон эдийн засгийн арга замыг байгуулах” талаар хэлэлцүүлгийг хийсэн. Үүнийг 5.30-ны хэлэлцүүлэг гэдэг бөгөөд 6.28 арга хэмжээг бодвол илүү нээлттэй, шинэчлэлд хүргэхүйц эдийн засгийн арга гэдэг үүднээс улсын хэмжээнд хэрэгжиж байна⁴. 5.30-ны арга хэмжээ нь 2015 оноос эхлэн бүх хоршоо, аж ахуйн нэгжүүд нь өөрийгөө хянасан менежментын тогтолцоог нэвтрүүлэн хамтарсан нэгдлийн нэгжийг арилгаж гэр бүлийн нэгжийг нэвтрүүлсэн.

Гэр бүлийн 1 хүн ам тутамд газар 1000 пёныг өгч орлогын 40 хувийг улс, 60 хувийг хувь хүн авах юм. 5.30-ны арга хэмжээ нь 2012 оны 6.28-ны арга хэмжээг бодвол илүү хүчирхэг эдийн засгийн шинэчлэлийг хийх арга хэмжээ юм.

2014 оны 6 дугаар сард Хамтарсан Хөрөнгө Оруулалтын Хороо, Үндэсний Эдийн Засгийн Хөгжлийн Хороо, Худалдааны Яам зэргийг нэгтгэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах Гадаад Эдийн Засгийн Яамыг байгуулан Чусоны эдийн засгийн хөгжлийн холбооны төрийн бус байгууллагууд бас байгуулагдсан. 2014 оны 9 дүгээр сард Хятадын Дайланд “Чусоны хөрөнгө оруулалтын танилцуулга”-ыг зохион байгуулсан бөгөөд хөрөнгө оруулалтын зорилгоор Умард Солонгост айлчлал хийх тохиолдолд Умард Солонгост айлчлах хүсэлтийг 10 хоногийн дотор шийдэж өгөх ба бүтээн байгуулалттай холбоотой материалыг авах талаар хүсэлт гаргавал илгээх болно хэмээн тайлбарласан.

2014 оны 7 дугаар сарын 23-нд зургаан эдийн засгийн хөгжлийн бүсийг нэмж зарласан бөгөөд Расоны эдийн засаг, худалдааны бүс, Хванкымпён, Вихва арлын эдийн засгийн бүс, Шиньжү олон улсын эдийн засгийн бүс, Кесоны аж үйлдвэрийн бүс, Кымган уулын олон улсын аялал жуучлалын тусгай бүс зэрэг таван эдийн засгийн тусгай бүс болон арван есөн эдийн засгийн хөгжлийн бүсээр нэмэгдсэн. 2014 онд төрөл бүрийн семинар, танилцуулга зэргээр Умард Солонгосын

4. Энэ хэлэлцүүлэгт Ким Жон Ун нь “Социалист цэцэглэн хөгжсөн их улсыг амжилттай байгуулахын тулд хөгжлийн бодит шаардлагад нийцсэн бидэнд тохирсон эдийн засгийн арга замыг байгуулах ёстой..... Эдийн засгийг хамгаалах арга замыг байгуулах явдал нь өнөөгийн эдийн засгийн болон цөмийн зэвсгийн байгуулалтыг хийх талаарх намын стратегийн чиг шутмын зорилгод хүрэх бөгөөд цэцэглэн хөгжсөн улсын байгуулалтыг урагшуулахад яг тохирсон шаардлага юм.

Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ ба Си Зиньпингийн нарны илч бодлого

эрх баригчид нь гадаадын эрдэмтэд, идэвхтэнүүдэд 2015 онд “Расоны хамтарсан хорооны загвар”-ыг бусад эдийн засгийн тусгай бүсэд хэрэглэх явдал бөгөөд цаашид хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт нэгж болон хувь хүний бие даасан байдлыг илүү гүнзгийрүүлэх явдал гэж тайлбарлаж байсан.

И Мён Бак болон Пак Гын Хэгийн Умард Солонгосын талаарх эдийн засгийн хориг арга хэмжээ – 5.24-ний арга хэмжээний парадокс

Нарны илч бодлого нь Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн санаачилсан Өмнөд, Умардын хамтын ажиллагаа, эвлэрлийн төлөөх бодлого юм. 1994 онд Их удирдагч Ким Ир Сен нас барсанаас хойш Ким Жон Уны засаглал нь төрийн албан хаагчийн доройтол, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн уналт зэргээс болоод системийн хямралыг амсаж байна. Хүнс, эрчим хүчний хямрал нь системийн хямралыг бий болгосон. Тиймээс Өмнөд Солонгос зэрэг өрнөдийн орнуудын Умардын талаарх хатуу байр суурийг баримтлагчид нь Умард Солонгосын задралын онолыг дэлгэрүүлсэн. Клинтонь засаг захиргаа нь 1994 оны 10 сард Женевийн хэлэлцээр, 1999 оны 10 сард Перригийн илтгэл⁵-ээр дамжуулан Америк, Умард Солонгосын яриа хэлэлцээрийг явуулахуйц таатай бодлогыг явуулахад эрмэлзэж байсан⁶. Ким Дэ Жүн болон Клинтонь засаг захиргаанууд нь Ким Чен Ирийн дэглэмийг нээлттэй шинэчлэлийн замаар явахад нь чиглэл өгөх үүднээс улс төр, цэргийн асуудал болон эдийн засаг, нийгмийн

5. Энэ илтгэл нь Клинтонь засаг захиргаанаас Умардын талаарх таатай бодлогын суурь нь болсон бөгөөд Ким Дэ Жүний засаг захиргааны нарны илч бодлоготой уялдаа холбоотой байсан. Энэ илтгэлийн гол агуулга нь Солонгосын хойг дахь хүйтэн дайны үеийн байдлыг зогсоох гурван үе шат бүхий зорилгыг багтаасан. Эхний зорилго нь Умард Солонгос пуужин хөөргөхөө зогсоох, Америк Умард Солонгосын талаар авсан эдийн засгийн хориг арга хэмжээгээ зөөлрүүлэн харилцан холбоо барьж байх газрыг байгуулах зэрэг харилцаагаа хөгжүүлэхийн тулд хичээх тухай байдлыг агуулж байсан. Хоёр дахь шатны зорилго нь Умард Солонгос цөмийн зэвсэг, пуужингийн хөтөлбөрөө хөгжүүлэх явдлыг зогсоох, Америк, Япон нь Умард Солонгостой дипломат хэлэлцээг тогтмолжуулах явдал. Гурав дахь шатны зорилго нь Умард Солонгосын зүгээс Америк, Японтой дипломат харилцааг хөгжүүлэх, Өмнөд, Умард Солонгос нь бодит эв нэгдэл гэж харж болохоор Өмнөд, Умардын Холбоог байгуулах явдал юм. Гэвч Буш засгийн эрхийг барьсанаас хойш Перригийн илтгэлийг үргэлжүүлж чадаагүй.

6. Энэ хэлэлцээр нь Америк, Умард Солонгос хоёр улс санал солилцоход туслах ерөнхий хэлэлцээр юм. Энэ хэлэлцээрийн гол агуулга нь Умард Солонгос цөмийн үйл ажиллагаагаа зогсоох, оронд нь Америк орлуулах эрчим хүч (жил бүр яг 350 мянган ам долларын үнэ бүхий 50 мянган тонн мазут тос) нийлүүлэх, хөнгөн усны реактор бүхий эрчим хүчний станцыг байгуулахад тусламжаар ханган Умард Солонгос цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй, Умард Солонгостой улс төр, эдийн засгийн харилцааг хэвийн болгох явдал юм. Гэвч 9.11-ний террорист үйл явдлын дараагаар буюу 2002 онд Умард Солонгос, Америкийн харилцаа дордсон.

асуудлыг тусад нь салгаж шийдвэрлэхийн тулд улс төр, эдийн засгийн заагласан бодлогыг явуулж байсан. Тухайлбал, Умард Солонгосын эдийн засгийн нээлттэй шинэчлэлийн замаар явуулах үүднээс Өмнөд Солонгосын зүгээс Умард Солонгост оруулах хөрөнгө оруулалтын хязгаарлалтаа хүчингүй болгож, хөрөнгө оруулахыг хязгаарласан бизнесийн төрлийг багасгахын тулд “Хоёр Солонгосын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн түүнчлэн Умард Солонгосын Кымган ууланд аялал жуучлалын тусгай бүс, мөн Кесоны аж үйлдвэрийн цогцолборыг байгуулан Умард, Өмнөдийн хоорондын харилцаа огцом өсөн нэмэгдсэн. 1998-2008 оны хооронд Ким Дэ Жүн болон Ну Мүн Хёний засаг захиргаанаас хэрэгжүүлсэн Нарны илч бодлого, Клинтоны засаг захиргааны Перригийн процессийн үр дүнд Умард Солонгосын Өмнөд Солонгосын талаарх итгэх хэм хэмжээ нь нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хамтын ажиллагаанаас хамааран харилцан аюулгүй байдлын заналхийлэл буурсан үе байсан. Энэхүү үйл явц нь Европын хамтын ажиллагааны үйл явцын функционализмтай ойртсон адилхан процесс болсон. Умард Солонгосын талаарх Өмнөд Солонгосын засаг захиргааны либерал бодлого нь функционализмд үндэслэсэн улс төр, эдийн засгийг салангид авч үзсэн бодлого байсан. 2007 оны 12 дугаар сард Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчийн сонгуулиар засгийн эрх баригчид солигдож Өмнөд Солонгост нео консервативууд засгийн эрх барих болсон. 2009 онд И Мён Бакийн засаг захиргаа, 2013 онд Пак Гын Хэгийн засаг захиргаа нь Умард Солонгосын талаар хатуу байр суурийг баримтласан бодлогыг хэрэгжүүлэх болсон. 2009 онд Ким Жон Ун залгамжлагчаар тодорч, Ким Жон Ил-Ким Жон Ун хамтарсан засаглалын үеийг эхлүүлсэн. Ким Жон Ун нь өөрийн дэмжигчдийн хувийг нэмэгдүүлэхийн тулд хоёр дахь цөмийн туршилтаа хийсэн, Ёнпён арал руу буудсан хэрэг зэрэг “Солонгосын хойгт хурцадмал байдал-ыг бий болгосон. Үүнээс болоод И Мён Бакийн засаг захиргаа нь хориг арга хэмжээ авч байгаага мэдэгдсэн бөгөөд үүнийг нь 5.24-ний арга хэмжээ гэж нэрлэдэг. Энэ арга хэмжээндээ манай ард түмэн Умард Солонгост айлчлахыг зөвшөөрөхгүй, хоёр Солонгосын хооронд худалдааны харилцааг зогсоох, Умард Солонгост шинээр хөрөнгө оруулалт оруулахыг хориглох, тэр ч байтугай хүмүүнлэгийн зорилгоор

Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээ ба Си Зиньпингийн нарны илч бодлого

тусламж үзүүлэх явдлыг хүртэл хориглосон⁷. Тиймээс Өмнөд Солонгос, Америк, Японы зүгээс Умард Солонгост үзүүлж байсан туслалцаа нь зогссон. Өмнөд Солонгос, Америк, Японы туслалцаа зогссон болон Хятад, Америкийн зөрчилтэй нөхцөл байдалд Ху Зиньтао-Си Зиньпингийн засаг захиргаа нь Солонгосын хойгийн тогтвортой байдал, Умард Солонгосын системийг бэхжүүлэх зорилгоор Ким Жон Ун залгамжлагчийг дэмжиж байсан. Өөрөөр хэлбэл Хятад, Умард Солонгосын холбоотон хэмээх зүйл нь хадгалагдаж байгаа юм.

Хятад, Америкийн харилцаа ба Си Зиньпингийн Умард Солонгосын талаарх нарны илч бодлого

2009 оны 5 дугаар сард хийсэн Умард Солонгосын хоёр дахь удаагийн цөмийн туршилт нь Ким Жон Уны эрх мэдлийн залгамжлалыг үргэлжлүүлэхэд оршиж байсан. Ху Зиньтаогийн засаг захиргаа, Обамагийн засаг захиргаа нь Умард Солонгосын цөмийн туршилтыг ажиглаж байсан бөгөөд Умард Солонгосыг цөмийн зэвсэгээс ангижруулахад цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх стратегийн зохицуулалтыг хийж байсан. Ху Зиньтаогийн засаг захиргаа нь Умард Солонгосын талаар хатуу бодлого баримтлах болсоноор нөлөөгөө алдсан түүхэн туршлагаас харвал Ким Жон Уны эрх мэдлийн залгамжлалын үед Умард Солонгосын системийн тогтвортой байдал анхаарал тавьсан юм. Үүнээс гадна Ху Жин Тао Умард Солонгосын цөмийн зэвсэг нь цэрэг, аюулгүй байдлын талаасаа Хятадад аюул учруулахгүй мөн Өмнөд Солонгос, Япон, Тайван нь цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхгүй байна гэж үзсэн. Тиймээс Ху Зиньтао-Си Зиньпин нь цөмийн зэвсгийг тогтоон барих, эдийн засгийн тусламж үзүүлэх гэсэн Хятад маягийн нарны илч бодлогыг хэрэгжүүлсэн юм. Функционализмын хандлага талаас авч үзвэл Си Зиньпингийн Умард Солонгосын талаар авч байгаа эдийн засгийн хамтын ажиллагаа нь Өмнөд Солонгосын Ким Дэ Жүний нарны илч бодлоготой нэлээд адил төстэй байна. 2010 оны 8 дугаар сард Хятадын төрийн тэргүүн Ху Зиньтао, Умард Солонгосын дарга Ким Жон Илд Умард Солонгосын талаар явуулж буй Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа, бодлого

7. 2002 оны 1 сард Ерөнхийлөгч Буш муу ерын тэнхлэгийн орнууд хэмээн "Иран, Ирак, Хойд Солонгос"-ыг зарласны улмаас Умард Солонгос, Америкийн харилцаа муудсан. Түүнчлэн энэ үед Япон иргэдийг хулгайлсан асуудал дахин сөхөгдөж Япончууд Умард Солонгос эсрэг хатуу хориг арга хэмжээ авсан.

дараах зүйлээр тодорхойлогдохыг мэдэгдсэн. Үүнд: Хятад, Умард Солонгос нь засгийн газар голлосон бизнесийг давамгайлан хийх бөгөөд зах зээлийн зарчим үйлчилсэн харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг явуулах юм.

2013 онд Хятадын дарга болсон Си Зиньпин Хятадын мөрөөдлийг уриалан гаргасаг бөгөөд энэ нь глобал бодлого болон Хятад Америкийн харилцаагаар шинэ хэлбэрийн их гүрний харилцааг бий болгох талаарх уриалга байсан. Си Зиньпингийн үеийн Умард Солонгос, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа нь глобал түвшин дэх Хятадын өсөлт болон Хятад Америкийн зөрчил, Солонгосын хойгийг тойрсон Өмнөд Солонгос, Америкийн Холбоотны харилцаа, Өмнөд Солонгос, Японы цэргийн хамтын ажиллагааны зөвлөлгөөн, Өмнөд Солонгос, Хятадын маргаан улмаар Умард Солонгосын дэглэмийн хямралын гүнзгийрэлт зэрэг суурь дээр явагдаж байна. Хятад, Америкийн зөрчилт нөхцөл байдлын талаас авч үзвэл Си Зиньпин нь Умард Солонгосыг геополитикийн талаас нь “буфер бүс” төдийгүй гео эдийн засгийн талаасаа ач холбогдол бүхий “хамтын ажиллагааны түнш” гэж үздэг.

Си Зиньпин болон Ким Жон Уны эдийн засгийн хамтын ажиллагааны дилемма

Си Зиньпингийн бүс нутгийн орнуудын тогтвортой байдлын асуудлын үндсэн ашиг сонирхлуудын нэг нь Ким Жон Уны дэглэмийн тогтвортой байдал юм. Иймд Си Зиньпин нь Ким Жон Уны дэглэмийг улс төр, нийгмийн талаас нь тогтвортой байлгах, цөмийн зэвсэг болон тив алгасах балластик пуужингийн туршилт зэрэг цэргийн өдөөн хатгалагийг зогсоох, түүнчлэн эдийн засгийн нээлттэй шинэчлэлд чиглүүлэх ёстой гэсэн харилцан зөрчилдсөн зорилгыг нэг цаг үед биелүүлэх ёстой гэсэн зөрчилд орсон.

Дэглэмийн хямралыг амсаж буй Ким Жон Уны хувьд социалист ах дүү орны эдийн засгийн хамтын ажиллагаа, тусламж нь улсын оршин тогтнол, дэглэмийг хэвээр хадгалах зайлшгүй шаардлагатай зүйл болж байгаа бодит байдлыг хүлээн авч буй шатанд байна. Гэсэн хэдий ч Ким Жон Ун бас Умард Солонгос, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа гүнзгийрсэнээс болж зөрчилтэй тулгарсан. Умард

Солонгосын Хятадын талыг барьсан эдийн засгийн бодлогоос болоод Умард Солонгосын эдийн засгийн хамаарал нь хэт их хэмжээнд хүрсэн. Пёнъян болон хилийн бүс нутаг нь юанийн бүс болсон бөгөөд ашигт малтмалын ашиглалтын байдлын талаарх Умард Солонгос, Хятадын туршлага нь Умард Солонгосын эдийн засгийн боломж, суурийг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл Ким Жон Ун нь Си Зиньпингийн хөндлөнгөөс оролцох байдалд хаалт хийх, Хятадыг ашиглан Өмнөд Солонгос, Америк, Японы Умард Солонгост тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээг хязгаарлан барих бодлогыг хэрэгжүүлэхтэй зэрэгцүүлэн Хятадаас ирэх эдийн засгийн үр ашгийг баталгаажуулах ёстой гэсэн диллема гарч байна.

Монголын сонголт

Монгол Улс нь өргөн уудам нутаг дэвсгэр, арвин их байгалийн баялаг, цөөн хүн амтай. Түүнчлэн геополитикийн талаасаа их гүрэн Хятад, Орос хоёрын дунд оршдог орны хувьд гуравдагч хөршийн хамтын ажиллагаа шаардлагатай байдаг. Хятад, Америкийн зөрчилтэй байдал дээр Өмнөд Солонгос, Америк, Японы хамтын ажиллагаа, Хятад, Умард Солонгосын холбоотны баг бөх бүтэц байхын зэрэгцээ Хятад, Умард Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагаа улам бүр ойртох төлөвтэй байна. Солонгосын хойг дахь ийм нөхцөл байдалд Монгол Улс нь ямар стратегийн сонголтыг хийх вэ гэдэг асуулт тавих шаардлага гарч байна.

Нэгдүгээрт, Умард Солонгос нь Монголын хувьд гуравдагч хөршийн боломж байгаа эсэх. Монгол Улс нь түүх, соёлын хувьд Өмнөд Солонгос төдийгүй Умард Солонгост нэлээд сайн имиштэй. Ялангуяа, хүйтэн дайны үед Монгол Улс нь ард түмний өргөл барьцаар Солонгосын дайн, дайны дараах сэргээн босголтод нэлээд хэмжээний тусламжийг үзүүлсэн. Хойшид Умард Солонгосын системийн шилжилтийн үйл явцын талаарх таамаглалууд нэлээд байдаг бөгөөд Монгол Улсын туршлагыг Умард Солонгост тайлбарлавал Умард Солонгосын эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд тус дэм болох юм.

Хоёрдугаарт, Си Зиньпингийн ЗХА-ийг хөгжүүлэх төлөвлөгөө болон Ким Жон Уны эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээний

нөлөөгөөр Солонгосын хойг, манжуур, ОХУ-ын алс дорнод зэрэг нь эдийн засгийн хохирол амсах юм. Ким Жон Уны нээлттэй шинэчлэл нь Солонгосын хойг дахь Монголын нөлөөг тэлэх нэг боломж юм. Умард Солонгосын тусгай бүс нь гадаадын компаниуд хөрөнгө оруулах явдлыг зөвшөөрч байна. Хятад, Орос, Өмнөд Солонгос, Япон зэрэг бүс нутгийн орнуудын компаниуд хөрөнгө оруулах төлөвтэй байна. Монгол Улс нь нийслэл Пёнъян, Шиньжү, Насон зэрэг хилийн бүсийн эдийн засгийн тусгай бүсийн өөрчлөлтөд анхаарлаа хандуулан хөрш орнуудын дэвшилтэт байдалд судалгаа хийж Умард Солонгосын эдийн засагт үзүүлэх Монголын нөлөөг сахин хамгаалах хэрэгтэй.

Гуравдугаарт. Умард Солонгос ажиллах хүчээ Хятадын зүүн хойд хэсэг, Оросын Алс Дорнодод олон арван мянгаар нь илгээсэн бөгөөд олон улсын аж үйлдвэрийн цогцолборыг бүрдүүлж байна. Монгол Улсын дэд бүтэц, уул уурхайн салбарт ажиллах хүч хомсдолтой байгаа тул Умард Солонгосоос ажиллах хүчийг авах шаардлага байна. Умард Солонгосоос илгээсэн ажиллах хүч нь Монголоос буцан эх нутагтаа очсоны дараа Умард Солонгосын дундаж давхаргын элит болох юм. Эдгээр хүмүүс нь Умард Солонгост Монголын талаарх ардын дипломатын үүргийг гүйцэтгэх ёстой. Энэ нь ЗХА болон Солонгосын хойгт энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөө Монголын оруулж байгаа хувь нэмэр болохын зэрэгцээ Өмнөд Солонгос дахь Монголын стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлэх дипломат аргаар аюулгүй байдлаа хангах нэг арга хэмжээ юм.

Ном зүй

한국연합뉴스, 2013년 3월 18일.

김정은의 담화, 2014년 5월30일, “당.국가.군대기관 책임일군(간부)들에게 ‘현실 발전의요구에 맞게 우리식 경제관리방법을 확립 할데 대하여’

필자와 김일성대학 교수들과의 토론(중국 연변대 두만강포럼), 2014년 10월 11일.

중국공산당 당교 ZaoHuji교수의 발표(한국, 세계북한학학술대회), 2014년 10월 28일.

일본 동경대 명예교수 Wada Haruki 교수와의 인터뷰(한국), 2014년 10월 28일.

필자와 북경대 김경일 교수와의 인터뷰(한국), 2014년 11월 23일.

필자와 북경대 김동길 교수와의 인터뷰(일본), 2014년 2월 3일.

필자의 북중국경지대 및 극동러시아 답사, 2014년 7월-8월, 10월 박종철, 중국의 대북한 관계의 역사, 현황, 그리고 전망 -‘김정은의 체제유지와 ‘시진핑의 현상유지강화’의 타협으로서 ‘적대적 동맹’-(The Past, Present and Future of China’s Relations with North Korea - the Adversarial Alliance as a Compromise between Kim Jong-Un’s Regime Stability and Xi Jinping’s Status Quo Plus), 한국국방대 안보문제연구소, 미발간원고.

박종철, “중국의 대북 경제정책과 경제협력에 관한 연구,” 『한국동북아논총』제 17집 제 1호(2012).

박종철·정은이, “국경도시 단둥과 북한 사이의 교류와 인프라 현황에 관한 분석.” 『한국동북아논총』, 제72호(2014).

정은이, 박종철, “중국의 대북한 무역에 관한 연구 - 무역 관행과 행태 및 행위자의 변화추세에 따른 역동성을 중심으로-,” 『통일문제연구』 제26권 2호 (2014).